



Нийт хугацаа: 60 минут орчим
Насны бүлэг: 11–14 насныхан

НҮБ-ын 80 ЖИЛИЙН ОЙГ ХАМТДАА ТЭМДЭГЛЭЕ СЭДЭВТ ДУНД АНГИЙН СУРАГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



Сургалтаас хүлээх үр дүн

- Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) гэж юу вэ, НҮБ яагаад байгуулагдсан тухай ойлголттой болох
- НҮБ-ын үйл ажиллагааны тухай ярилцах
- Өнгөрсөн 80 жилийн хугацаанд НҮБ дэлхийг хэрхэн өөрчилсөн талаар эргэцүүлж ярилцах
- Ирээдүйд НҮБ юу хийж болох талаар ярилцаж санал солилцох

Ашиглах материал

- Сурагчдад зориулан хялбаршуулан бэлтгэсэн материалыг тараах (НҮБ-ын онцлох үйл явдлууд, НҮБ-ын системийн байгууллагуудын Лого, гэх мэт).
- Цаас, үзэг, холбогдох хэрэглэгдэхүүн
- НҮБ-ыг танилцуулсан богино хэмжээний видео үзүүлэх

Видео: НҮБ гэж юу вэ?

https://youtu.be/Rn_fD-OfcMg?si=b0K09EGmins5asNh



Сургалтын хөтөлбөр

Алхам 1: Танилцуулга – НҮБ гэж юу вэ? (5-7 мин)



Сурагчдаас асуух: НҮБ-ын талаар сонсож байсан уу? НҮБ ямар ажил хийдэг гэж та бодож байна вэ?

Тайлбарлах нь:

Нэгдсэн Үндэстний Байгууллага гэж юу вэ?

Нэгдсэн Үндэстний Байгууллага буюу НҮБ нь дэлхийн бараг бүх улс орон найз болж, хамтран ажилладаг нэг том баг юм.

НҮБ нь 1945 онд буюу Дэлхийн Хоёрдугаар дайны дараа даян дэлхийд энх тайвныг тогтоож дайн тулаанаас сэргийлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Нийт 193 гишүүн улс НҮБ-д байдаг. Энэ жил НҮБ-ын үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ой болж байна.

НҮБ олон тусгай байгууллагатай бөгөөд тус бүр нь чухал ажил хийдэг
Тухайлбал:

- WFP (Дэлхийн хүнсний хөтөлбөр) хоол хүнс дутмаг гэр бүлүүдэд тусламж үзүүлдэг
- WHO (ДЭМБ) хүмүүсийг эрүүл байхад тусалдаг
- UNESCO түүх, соёлыг хамгаалж, боловсролыг дэмждэг

Дэлхий хүмүүсийн сайн сайхны төлөө НҮБ-ын 30 гаруй байгууллага ажилладаг.

НҮБ ба Монгол Улс

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүн болсон.

- Монголын хүүхэд, гэр бүлд боловсрол, эрүүл мэндийг сайжруулахад тусалдаг
- Байгаль орчныг хамгаалах, нүүдэлчдийн уламжлалыг дэмжиж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад тусалдаг
- Залуучуудад илүү олон боломж бий болгох, ирээдүйгээ өөрсдөө бүтээхэд нь дэмждэг
- Мөн Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгуудыг (SDGs) хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг

НҮБ-ын Логотип хүүхдүүдэд үзүүлж ярилцах: Дэлхийд ийм байгууллага байх нь яагаад чухал гэж бодож байна вэ?



Сургалтын хөтөлбөр

Алхам 2: НҮБ хүмүүст яаж тусалдаг вэ? (10 мин)

НҮБ-ын үйл ажиллагааны онцлох таван чиглэлийг танилцуулж ярилцах:
Дараах 5 чиглэлийг танилцуулах (дүрсэн тэмдэглэгээ/зургууд ашиглах):

1. Энх тайван – дайныг зогсоож, хүмүүсийг аюулгүй байлгах
2. Эрүүл мэнд – вакцин, цэвэр усаар хангах
3. Боловсрол – хүүхдүүдийг сургуульд сурахад нь туслах
4. Хүүхдийн эрх – хүүхэд бүр аюулгүй байж, хайр халамжтайгаар өсч торних
5. Эх дэлхий – байгаль дэлхийгээ хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх

Асуулт: Хүүхдүүд та нарт дээрх асуудлын аль нь хамгийн чухал вэ?

Алхам 3: Амжилт, сорилтын талаарх ойлголт (20 мин)

- НҮБ-ын онцлох үйл явдлын цагалбарыг танилцуулах:

Дасгал: НҮБ ололт амжилт гаргаж байгаа ч, тулгамдсан хэвээр байгаа асуудлыг тогтвортой хөгжлийн зорилттой нь холбож ярилцах (жишээ нь, "Сурч боловсрох эрх", "Олон сая хүүхэд сургуульд суралцаж чадахгүй байгаа").

Ангигараа хэлэлцэх: НҮБ цаашид ямар асуудалд гол анхаарлаа хандуулах ёстой гэж бодож байна вэ?

1948 – Хүний эрхийн түгээмэл тунхаглал

2015 – Эх дэлхийг хамгаалах Тогтвортой хөгжлийн зорилтуудыг баталсан.

1945 – НҮБ байгуулагдсан

1989 – Хүүхдийн эрхийн тухай конвенц

2025 – НҮБ байгуулагдсаны 80 жилийн ой!



Сургалтын хөтөлбөр

Алхам 4: НҮБ-ын ирээдүйг төсөөлөх (15 мин)

- 2045 онд буюу НҮБ 100 жилийнхээ ойг тэмдэглэх тэр үед НҮБ ямар байгаасай гэж бодож байгааг сурагчид асууж ярилцах
- "Сонин, сэтгүүлийн нүүр"-г гаргах (жишээ нь, "НҮБ бүх улс оронд энх тайвныг тогтоолоо", гэх мэт)
- "НҮБ-тай хамтран бүтээхийг хүсч буй миний дэлхий" гэсэн санааг агуулсан богино хэмжээний өгүүлэмж, шүлэг, дуу, зураг зохиох"

Алхам 5: Ойн баярыг тэмдэглэх (5 мин)

- "НҮБ 80 жил" гэсэн ангийн ажил зохиох: Сурагчид өөрсдийн зураг, мэдээлэл, шүлгийг танилцуулж ярилцах
- Богино хэмжээний жүжигчилсэн тоглолт (mini #KidsTakeover) зохиох: Сурагчид НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын дүрээр илүү сайхан ертөнцийг бүтээх санаа дэвшүүлж тоглох
- Сургууль, олон нийтийн дунд бүтээлээ солилцохыг дэмжих: Зохиосон шүлэг, дуу, зурсан зургаа #UN80, НҮБ-ын цахим хуудсуудыг дурдан цахим орчинд хуваалцах (зохимжтой гэж үзвэл)





СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА /11-14 НАС/



1. Нэгдсэн Үндэстний Байгууллага үүсэн байгуулагдсаны 80 жилийн ой болж байна!

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) гэж юу вэ?

- Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь 1945 онд буюу Дэлхийн Хоёрдугаар дайны дараа үүсэн байгуулагдсан.
- НҮБ-ын үндсэн зорилго нь энх тайвныг сахин хамгаалах, дэмжлэг хэрэгтэй байгаа хүмүүст туслах, даян дэлхийг илүү шударга, аюулгүй болгохын төлөө улс орнуудын хамтын ажиллагааг дэмжих юм.
- Өнөөгийн байдлаар НҮБ-д нийт 193 улс орон гишүүнээр элсээд байна.



Онцлох мэдээ: 2025 онд 80 жилийнхээ ойг тэмдэглэнэ!

2. НҮБ-ын Онцлох үйл явдлууд
НҮБ-ын онцлох чухал үйл явдлаас:

1945: Даян дэлхийд энхтайвныг сахин хамгаалахын тулд Дэлхийн Хоёрдугаар Дайны дараахан Нэгдсэн Үндэстний Байгууллага үүсэн байгуулагдсан.

1948: Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан

1979: Дэлхий дахинаа салхин цэцэг өвчнийг устгах кампанит ажлыг НҮБ манлайлан зохион байгуулсан

1989: Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенцид дэлхийн бараг бүх орон нэгдсэн

2000: Мянганы хөгжлийн зорилгуудыг баталсан

2015: Илүү сайхан дэлхий ертөнцийг бүтээхэд чиглэсэн 2030 оны Тогтвортой хөгжлийн зорилгуудыг баталсан

2020: НҮБ нь КОВИД-19 цар тахалтай тэмцэх чиглэлээр дэлхийн улс орнуудад туслалцаа үзүүлж ирсэн.

2025: НҮБ байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэнэ !



СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА /11-14 НАС/



3. Хүүхэд багачуудад чиглэсэн НҮБ-ын үйл ажиллагаа

- НҮБ-ын системийн олон байгууллага бий. НҮБ-аас хүүхдийн төлөө дараах 5 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:
- Энх тайван, Аюулгүй байдал – НҮБ-ын Энхийг сахиулагчид дайн тулаантай бүс нутгуудад амьдарч байгаа хүүхдүүдийг хамгаалах ажлыг хийж байна.
- Эрүүл мэнд – Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага нь дархлаажуулах вакцинаар хангах, өвчлөлтэй тэмцэх үйл ажиллагаа явуулж байна.
- Боловсрол, Соёл – НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь сургуулиудад туслах, өв соёлыг хамгаалах ажлыг хийж байна.
- Хүүхдийн эрхийг хамгаалах – НҮБ-ын Хүүхдийн сан нь хүүхэд бүр эрүүл, аюулгүй байж, сургуульд бүрэн хамрагдах эрхийг хангахад анхаарлаа хандуулж байна.
- Байгаль Орчин, Уур амьсгал – НҮБ нь ирээдүй хойч үеийнхнийхээ тусын тулд эх дэлхийгээ хайрлан хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна.





СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА /11-14 НАС/



4. Дасгал 1 – Амжилт, тулгарч буй сорилтыг харьцуулж ярилцах

НҮБ-ын ололт амжилт, тулгарч буй сорилтуудыг
шугаман зураасаар холбох

НҮБ-ын Амжилт: Салхин цэцэг
өвчнийг устгасан

НҮБ-ын Амжилт: Хүүхдийн
эрхийн тухай конвенц
батлагдсан

НҮБ-ын Амжилт: Дэлхийн
Тогтвортой хөгжлийн
зорилгуудыг баталсан

Сорилт: Олон сая хүүхэд сургуульд
хамрагдаж чадахгүй, аюултай
орчинд амьдарч байна

Сорилт: Ядуурал, уур амьсгалын
өөрчлөлт нь тулгамдсан асуудал
хэвээр байна

Сорилт: Урьдчилан сэргийлж болох
өвчнөөр хүүхдүүд эндсэн хэвээр
байна



5. Дасгал 2 – “Ирээдүйн Сонин”

2045 он буюу НҮБ-ын 100 жилийн ой болж байгаагаар төсөөл
Яг тэр мөчид, чи ямар асуудлыг хөндсөн сонин гараасай гэж хүсч
байна вэ:

Жишээлбэл, “НҮБ нь дэлхий дахинд энх тайвныг тогтоолоо –
Дэлхий дахинаа дайн хэзээ ч гарахгүй”

Таны хүсч буй агуулга: _____



СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА /11-14 НАС/



6. Дасгал 3 – НҮБ-ын 100 жилийн ой

Цагирган зураас дотор төсөөллөө зургаар, аль эсвэл бичгээр илэрхийлнэ үү? 100 жилийн ойгоо тэмдэглэх тэр мөчид, НҮБ-аас хийсэн байгаасай гэж бодож байгаа НЭГ ажлын санааг хэлнэ үү



7. Санал бодлоо хуваалцах, НҮБ-ын ойн баярыг тэмдэглэх!

- Ангийнхантайгаа санал бодлоо хуваалцах
- 100 нас хүрсэн НҮБ-ыг төсөөлсөн зурагт хуудас, шүлэг, зураг дүрслэл зохиох
- Илүү сайхан дэлхий ертөнцийг хэрхэн яаж бүтээх талаарх санал бодлоо илэрхийлж НҮБ-ын 80 жилийн ойг тэмдэглэх үйл явцад оролцоорой

Хичээлийн бататгал: НҮБ нь хүмүүсийг эвтэй нэгдмэл байлгахын төлөө байгуулагдсан. Илүү сайхан ертөнцийг бүтээх ирээдүйн удирдагчийн нэг нь Чи өөрөө гэдгээ санаарай



Сурагчдад зориулсан дүрсэн тэмдэглэгээ (icon)-ний хуудас



НҮБ үүсэн байгуулагдсаны 80 жилийн ой – Хүүхдийн сургалтад зориулсан дүрсэн тэмдэглээний хуудас. Багш нар дүрсэн тэмдэглэгээнүүдийг зурж хайчлан карт хэлбэрээр бэлтгэж болно.

Зурагт хуудас бүтээх – “100 жилийн дараа би ийм дэлхийг хүсэж байна” гэсэн зурагт хуудсыг дүрсэн тэмдэглэгээ ашиглан бүтээнэ. Сурагчид дасгал ажиллахдаа картыг ашиглана (тохируулах, ангилах, зурагт хуудас хийх, гэх мэт)

1. Энх тайван, Аюулгүй байдал

“НҮБ-ын Энхийг сахиулагчид дайн мөргөлдөөнтэй бүс нутгуудад амьдарч байгаа хүүхдүүдийг хамгаалах үйл ажиллагаанд оролцож байна”



2. Эрүүл мэнд

“Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага нь дархлаажуулалтаар дамжуулан хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа явуулж байна”



3. Боловсрол, Соёл

“НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь хүүхэд бүр сургуульд суралцах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн ажлыг хийж байна”



4. Хүүхдийн Эрх

“НҮБ-ын Хүүхдийн сан нь хүүхэд бүрийн эрүүл, аюулгүй орчинд төрж өсөх, боловсрол эзэмших, хөгжих эрхийг хангахын төлөө ажиллаж байна”



5. Байгаль Орчин, Уур амьсгал

“НҮБ нь ирээдүй хойч үедээ зориулан эх дэлхийгээ хайрлан хамгаалах үйл ажиллагаа явуулж байна”

